



Та өдөрт хэдэн хүнтэй ярилцлага хийдэг вэ? Таны ажил горилогчид тавьдаг асуултууд юу вэ? Та зөв асуулт тавьдаг гэдэгтээ итгэлтэй байна уу?

Carole Martin-ий “Boost your hiring IQ” номоос сэдэвлэсэн энэхүү гарын авлагаар та ажил горилогчтой хийх ярилцлагын ур чадвар, туршлагаа шалгах боломжтой. Нийт 25 асуултанд та хариулах ба хариулт болгоны доор зөв хариулт,

яагаад гэдэг тайлбар бий. За эхэлцгээе, амжилт хүсье.

### 1. Хүнийхээ тухай ерөнхий ойлголт авахын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?

- A. CV-нийхээ дагуу өөрийгөө танилцуулна уу?
- B. Өөрийнхөө тухай ярина уу?
- C. Өөрийгөө гурван үгэнд тайлбарла гэвэл?

Хариулт:

- Сайн асуулт: (B).** Учир нь энэ нь дэлгэрэнгүй хариулах нээлттэй асуулт бөгөөд хариулт нь таньд тэр хүний тухай ерөнхий зургийг өгөх учиртай. Тэр хүн асуултандаа төвлөрч зөв хариулж байна уу халиад алга болж байна уу, шүлэг шиг цээжилсэн юмаа ярьж байна уу гэх мэт
- Дунд зэрэг (C).** Хэрвээ хариултыг авахдаа жишээгээр батал гэж асуувал хүчирхэг асуулт болж чадна. Жнь: зохион байгууллалттай хүн гэж өөрийгөө тодорхойлсон бол үүнийгээ жишээгээр батлаач гэж асуух
- Муу (A).** Зүгээр л урдаа байгааг уншаад ойлгох юмыг асуух шаардлага байхгүй.

### 2. Өрсөлдөгчидөөсөө онцгойрох юу тэр хүнд байгааг мэдэхийн тулд та аль асуултыг илүү тохиромжтой гэж үзэж байна вэ?

- A. Чамайг яг юу бусад хүмүүсээс онцгой болгож, ялгаруулдаг вэ?
- B. Яагаад би чамайг ажилд авах ёстой гэж бодож байна вэ?
- C. Өөр хүнд байхгүй ямар чадвар чамд байгаа вэ?

Хариулт :

- Сайн: (A).** Энэ асуулт нь тэр хүнийг өөрийгөө юуг гэж дүгнэдэг вэ гэдгийг мэдэх боломжтой асуулт юм.
- Дунд: (C).** Энэ асуултыг асууснаар тэр хүний ажлыг зарыг хир ойлгосныг олж мэдэх боломжтой
- Муу: (B).** Яагаад гэсэн асуултаас аль болох татгалзах хэрэгтэй

**3. Хүсэж буй ажлыг хийж чадах чадвартай эсэхийг шалгахын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- A. Өөрийгөө энэ ажилд хир тохиромжтой гэж бодож байна вэ?
- B. Энэ ажилд амжилттай байхад ямар чадвар хамгийн хэрэгтэй гэж бодож байна вэ?
- C. Энэ ажлыг та хийвэл яг ямар илүү зүйлийг амлаж/санал болгож чадах вэ?

**Хариулт:**

- Сайн: (B).** Энэ хариултыг дараад нь баталгаажуулах асуулт асууж болох учир хамгийн сайн нь. Хайрцагнаас гадна сэтгэх боломжийг олгох/шалгах боломжтой.
- Дунд: C.** Өөрөөр хэлбэл та ямар давуу талыг энэ ажилд санал болгох юм л гэсэн асуулт учир ийм хэлбэрээр асуух нээх шаардлагагүй
- Муу: (A).** Хэтэрхий хаалттай асуулт

**4. Зан ааш нь ажилд тохирох эсэхийг шалгахын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- A. Та одоо ажиллаж байгаа ажлын хамт олныхоо уур амьсгалыг хэрхэн дүрслэх вэ?
- B. Та ямар хүмүүстэй ажиллах дуртай вэ?
- C. Намайг чамайг ажилд авахыг хүсэл төрүүлэх зан төрхийн 3 байдлаа нэрлэнэ үү?

**Хариулт**

- Сайн: A.** Нэгээс илүү үгээр хариулах асуулт мөн. Хариулт бүрийг дахин тодруулж ухан асуух боломжтой.
- Дунд: C.** Гуравхан үгээх хариулчих боломжтой асуулт.
- Муу: B.** Тэр хүний талаар мэдээлэл өгч чадахгүй муу асуулт

**5. Ярилцагчийн урам авах хүчин зүйлийг тодорхойлохын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- A. Та ажилдаа хамгийн сэтгэл хангалуун үе хэзээ вэ? ямар үед?
- B. Байнга давтагддаг нэг төрлийн ажлыг хийхэд ямархуу санагдах вэ?
- C Ажил дээрээ хамгийн их хүндлэгдэж байсан тэр мөч чинь юу байсан бэ?

**Хариулт**

- Сайн: (A).** Юунд сэтгэл хангалуун байдгийг нь мэдэх юм бол юу тэр хүнд урам өгдөгийг мэдэх боломжтой
- Дунд: C.** Зарим хүмүүс ажилдаа тийм мөчийг эдлэж үзээгүй ч байж болно.
- Муу: B.** Хаалттай асуулт. Тийм үгүй гэсэн хариултыг өгч болно

**6. Тэр хүний ажлын үр дүнд нөлөөлж болох асуудалтай талуудыг мэдэхийн тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- А. Та өмнөх ажилдаа ямар нэг байдлаар ажлаа гүйцэтгэж чадахгүй болох шалтгаан байна уу?
- В. Та өмнөх ажлаасаа ямар нэгэн сөрөг санал, шүүмжлэл авч байсан уу?
- С. Танд эрүүл мэндийн талаар ямар нэг асуудал байгаа юу?

**Хариулт**

- Сайн: (А).** Эрүүл мэндийн талаар хязгаарлагдмал хүнд асуулт тавихдаа зөвөөр асуух шаардлагатай учир энэ нь тохиромжтой асуулт
- Дунд: В.** Энэ нь хангалттай тодохрой асуулт биш
- Муу: С.** Энэ нь зөвхөн муу ч биш бас хууль ёсны бус асуулт

**7. Багийнхантайгаа хир тохиромжтой байх эсэхийг мэдэхийн тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- А. Хамтран ажиллагсад чинь чамайг юу гэж дүгнэдэг вэ?
- В. Ажил дээрээ хэн нэгэнтэй санал зөрөлдөж байсан уу, тийм бол ямар юман дээр гэдгээ яриач?
- С. Босстойгоо болон хамтран ажиллагсадтайгаа санаа нийлэхгүй тохиолдол гарч байсан уу?

**Хариулт**

- Сайн: (В).** Зан байдлаа тайлбарлаж хэлэхийг асуусан учир энэ нь хамгийн сайн хариулт мөн
- Дунд: А.** Энэ асуултын хариулт нь бусад нь түүнийг хүнийх нь хувьд юу гэж дүгнэдэг гэдгийг л мэдэх боломжтой. Харин ямар нэг асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар нь асуувал хүчтэй болж өгнө
- Муу: С.** Тийм үгүй гэх хаалттай асуулт бөгөөд хариулт өгсөн ч үнэн гэж итгэх арга үгүй тийм л асуулт

**8. Алдаагаа хэрхэн даван туулах чадварыг шалгахын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- (А). Карьерийн чинь хамгийн том завсарлага/уналтын үе ер нь юунаас болсон бэ?
- В. Карьерынхаа явцад эргэж очоод өөрчилчихмөөр санагддаг зүйл тань юу вэ?
- С. Хугацаанаас хэтрүүлж юмыг хийж/хүлээлгэн өгч байсан уу?

**Хариулт**

- Сайн: (А).** Энэ асуултаас олон янзын хариултыг олж авч болно. Ер нь ямар асуудал гарсан бэ гэдгээсээ асуудлыг хэрхэн даван туулсан тэрхүү процесс нь л хамгийн чухал байдаг.
- Дунд: В.** Нарийвчлан асуугаагүй учир дундаж хариулт. Дахин ухаж асууж болно. Энэ асуултаас тэр хүний алдаанаасаа туршлагаасаа хир зэрэг суралцдаг талаар мэдэж авч болно.

- Муу:** С. Тэр хүн хариултаа өөрөө л баяжуулахгүй бол юуг олж авах боломжгүй хаалттай асуулт

**9. Алдаанаасаа хэрхэн суралцах чадварыг шалгахын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- А. Алдаа хийснээрээ сурсан хамгийн чухал хичээл тань юу байсан бэ? /ажил дээр/  
В. Чиний хийсэн алдааны төлөө хэн нэгэн хариуцлага хүлээх болоод байвал чи юу хийх вэ?  
С. Бид бүгд алдаа гаргадаг. Чиний хамгийн сүүлд ажил дээр гаргасан алдаа юу байсан бэ?

**Хариулт**

- Сайн:** А. Хамгийн сайнаараа харагдах ёстой байгаа ярилцлага дээрээ алдааныхаа талаар ярих нь хүмүүст хэцүү. Гэвч энэ нь сөрөг биш эерэг асуулт, анхааралтай сонсвол их зүйлүүдийг мэдэх боломжтой
- Дунд:** С. Ок асуулт, сайн биш. Алдаа хийх нь байдаг зүйл гэдгийг та өөрөө хүлээн зөвшөөрсгөөр тэр хүн таньд нээлттэй байх боломжийг олгож байна.
- Муу:** В. Тодорхой санаагаа та асууж чадахгүй байна. Гэвч тухайн хүний үнэнч зан байдлын талаар мэдэх боломжтой

**10. Тэр хүний туршлагынх нь таньд хэлэгдээгүй өнгөрсөн нуугдмал зүйлийг олж тогтоохын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- А. Өөрийнхөө талаар ямар нэг сөрөг зүйлийг надад хэлээч?  
В. Өргөдөл дээрээс чинь харахад ажиглагдаад байгаа ажил хийгээгүй юм шиг цаг хугацааны завсарлагаа юу гэж тайлбарлах вэ?  
С. Чи энэ ажилд хэтэрхий сайн гэж харагдаад байна. Юу чамайг энэ ажилд татаад байна?

**Хариулт**

- Сайн:** С. Ажлын шаардлагад хэтэрхий сайн хүнийг ажилд авах нь ухаалаг сонголт биш боловч тэр хүний яагаад энэ ажлыг сонгох болсон шалтгааныг сонсох хэрэгтэй.
- Дунд:** В. Ок асуулт. Сайн биш. Мэдээлэл авч тодруулах ёстой асуултуудын л нэг. Ямар ч шалтгаанаар хүн ажлын завсарлага авсан байж болно. Ялангуяа эмэгтэйчүүд болон өвчний улмаас бий болсон ажлын завсарлага
- Муу:** А. Тодорхой биш учир хамгийн сул асуулт. Ярилцаж буй 2 хүнийг хоёуланг нь эвгүй байдалд оруулж болох “эвгүй” асуулт

**11. Хийж гүйцэтгэсэн хамгийн бахархмаар ажлыг нь олж тогтоохын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- А. Ямар нэг ажлыг/төслийг амжилттай хийж гүйцэтгэснийхээ үр дүнд шагнал урамшуулал авч байсан уу?

- В. Намайг мэдээсэй гэж хүсэж байгаа 3 амжилтаа нэрлэнэ үү  
С. Хийж байсан бүх ажлуудаасаа хамгийн их бахархаж явдаг нь ямар ажил байсан бэ?

#### Хариулт

- Сайн: С.** Хамгийн сэтгэл ханамжийг авч байсан тэр дурсамжийг асууж байгаа учир хамгийн сайн асуулт. Цаашаа дэлгэрүүлээд асуувал бүр сайн. Жнь: “чиний зүгээс юу хийсэн болоод энэ ажил чамд тааламжтай байсан бэ” г.м
- Дунд: В.** Лимиттэй асуулт. Дэлгэрүүлж асууснаар асуултыг сайн болгоно. Ж нь: Энд та яг юу хийсэн бэ? Чиний үүрэг роль чинь юу байсан бэ?
- Муу: А.** Энэ төрлийн мэдээллийг олж авахад хэрэглэгдэх хамгийн сул асуулт. Мөн хэтэрхий бага хүрээг хамарсан гэдгээрээ ашигтай мэдээлэл олж авахад хангалттай бус

### 12. Ярилцагчийн давуу талыг олохын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?

- А. Хамт ажиллагсдаас чинь би чиний давуу талыг асуувал тэд надад юу гэж хэлэх бол?  
В. Чиний давуу тал юу вэ?  
С. Чи энэ байгууллагад юуг хийж бүтээж чадах вэ?

#### Хариулт

- Сайн: А.** Хэдийгээр энэ нь чиний давуу тал юу вэ гэсэн энгийн асуулт боловч үүнийг арай өөрөөр эргүүлж бусдын дүгнэлтийг оруулж өгснөөрөө хамгийн сайн асуулт болж чадаж байна.
- Дунд: В.** Энэ бол хүн болгоны хувьд асууж магадгүй хэмээн бодож бэлтгэдэг асуулт. Сайн асуулт болов ч өөр төрлөөр асуух хэрэгтэй.
- Муу: С.** Энэ нь хэтэрхий тодорхой бусь том хүрээг хамарсан. Олон төрлийн зүйлийг хүн хийж болох болов ч хэрвээ энэ асуултыг асуувал илүү тодорхой байх хэрэгтэй

### 13. Багаар болон хамтын ажиллагаагаар ажиллаж байсан туршлагыг нь судлахын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?

- А. Хүмүүстэй ажиллаж байхдаа хамт олон, багийнхаа хамтын ажиллагааг дэмжих ямар нэг зүйл хийж байсан уу?  
В. Хүмүүст урам өгч хурцалж байсан сайхан дурсамжаасаа хуваалцаач?  
С. Чи багийн ажиллагааг доош нь татдаг хүнтэй нэг баг болон ажиллаж байсан туршлага байна уу, хуваалцаач?

#### Хариулт

- Сайн: В.** Энэ төрлийн асуултанд мэдээллийг авахад хамгийн тохиромжтой асуулт. Багаар ажиллахад бие биенээ дэмжин хурцлах нь хамгийн чухал гэдгийг ойлгодог хүн гэдгийг нь мэдэж авах боломжтой

- Дунд: С.** Ок асуулт. Үүгээр багийн дунд ямар нэг асуудал гарахад энэ хүн ямар байдалтай оролцох вэ гэдгийг мэдэж авах боломжтой
- Муу: А.** Ганц үгээр хариулчихаж болох сул асуулт.

**14. Хэрвээ энэ хүн ажилд орсон тохиолдолд хамгийн даван туулахад бэрхшээлтэй зүйл нь юу байж болохыг тогтоохын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- А. Энэ ажлыг өөрийнхөө сүүлд хийж байсан ажилтай харьцуулаач
- В. Шинэ төрлийн бэрхшээлтэй тулгарвал чи ямар алхмуудыг хийх вэ
- С. Энэ ажилд чамд гарч болох хамгийн том бэрхшээл юу гэж бодож байна

#### **Хариулт**

- Сайн: А.** Энэ асуултаас энэ хүн ямар ажлыг хийж дассан болоод ямар ажил нь тэр хүний хувьд цоо шинэ зүйл вэ гэдгийг ойлгох боломжтой
- Дунд: С.** Энэ бол тэр хүний ямар талаараа сул вэ гэдгийг л асууж байгаа асуулт. Харин энэ асуултыг хариулж байгаа байдлаас нь тэр хүний өөрийн талаар сөрөг мэдээллийг хэрхэн хүнд хүргэж байгааг ажиглах боломжтой
- Муу: В.** Энэ төрлийн мэдээлэлд хамгийн тохиромжгүй асуулт. Харин өнгөрсөн туршлагынх нь талаар асуувал илүү дээр байж болох

**15. Ямар тал дээрээ илүү сайн бэ гэдгийг нь тогтоохын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- А. Чи өөрийгөө бусдаас илүүтэйгээр ямар төрлийн зүйлийг мэддэг, ямар зүйлд илүү сайн гэж боддог вэ
- В. Энэ ажилд чиний зүгээс өгч чадах хамгийн хүчирхэг/том чадвар эсвэл давуу тал чинь юу вэ
- С. Өөрийн мэргэжлийн хүрээнд гарч буй хөгжил дэвшилтэй чи хэрхэн хөл нийлүүлж чаддаг вэ

#### **Хариулт**

- Сайн: А.** Энэ асуултаас та тухайн хүнд энэ ажилд шаардагдах тэрхүү чадварууд байгаа эсэхийг мэдэх боломжтой. Мөн хийх гэж байгаа ажлынхаа талаар хир мэдлэгтэй байгааг шалгах боломжтой
- Дунд: С.** Энэ асуултыг илүү үр дүнтүй болгохын тулд бас илүү асуултуудыг ухан асуух хэрэгтэй. Хариултыг нь мөн баталгаажуулж шалгах хэрэгтэй, тиймээс ярилцлага авч байгаа та ч гэсэн мэдлэгтэй байх
- Муу: В.** Энэ нь давуу талыг асууж байгаа бас л нэг өөр хэлбэр юм

**16. Харилцааны чадварыг нь ямар түвшинд эсэхийг олж тогтоохын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- А. Харилцааныхаа чадварыг үнэл гэвэл сайн, дундаж, дунджаас дээгүүрийн алинд нь орох вэ?
- В. Чиний одоогийн ажлын хэд орчим хувь нь сайн харилцааны ур чадварыг шаарддаг вэ? Энэ хувь нь ажлын тань бусад үүрэг рольтой хэрхэн нийцэж байна?
- С. Хамт ажиллагсад чинь чиний харилцааны чадварыгхэрхэн үнэлэх бол

#### Хариулт

- Сайн: В.** Хэдийгээр асуултын эхний хэсгийг ганц үгээр хариулах боломжтой боловч дараагийн хэсгийг нэмж асууснаар ярилцагчийн харилцааны чадварыг бүхэлд нь мэдэх боломжийг олгоно.
- Дунд: С.** Энэ тохиолдолд энэ асуулт нь хамгийн хүчирхэг байж чадахгүй. Харилцааны чадвараа бусдын үгээр тайлбарлах нь хүнд харьцангуй амархан байдаг.
- Муу: А.** Иймэрхүү асуултаар ямар нэг чанартай мэдээллийг ярилцагчаас олж авах боломжгүй. Ярилцлага гэдэг бол өөрийгөө худалдах боломж, энэ үедээ хэн ч өөрийнхөө хамгийн чухал байх ёстой чадварыг дундаж гэж хэлэхгүй нь ойлгомжтой

**17. Нарийн ширийн жижиг зүйлд анхааралтай хандах чадварыг тодорхойлохын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- А. Чи нарийн ширийн жижиг зүйлийг зохицуулахдаа хир вэ?
- В. Нарийн ширийн жижиг зүйлүүдийг зохицуулахдаа 1-10 хооронд өөрийгөө үнэл гэвэл чи хэдэн оноо авах вэ?
- С. Одоогийн болон өмөх ажлынхаа ямархуу нарийн жижиг зүйлсүүдийг чи зохицуулдаг/ зохицуулдаг байсан бэ?

#### Хариулт

- Сайн: С.** Өмнөх туршлагыг нь асууж байгаа учир энэ нь хамгийн хүчирхэг асуулт болж чадаж байна. Энэхүү асуулт нь мөн тэр хүний өмнөх туршлагын талаар илүү нарийн тодруулж асуух боломжийг олгож байна.
- Дунд: В.** Дугаар нь хэмжүүрийн тодорхой систем болов ч яагаад энэ дугаараар өөрийгөө үнэлснийг нь асуухаас найш энэ нь хангалттай мэдээлэл байж чадахгүй
- Муу: А.** Энэ асуултанд хариулахдаа хүн “би сайн” эсвэл “би муу” гэж бараг л хариулахгүй ба мөн д илүү асуултаар ухан ярилцах хэрэгтэй

**18. Зохион байгуулах чадварыг тодорхойлохын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- А. Өөрийнхөө зохион байгуулах чадвараа та хэрхэн үнэлэх вэ?
- В. Хэрэв чамд хэд хэдэн давхацсан ажил байвал ямар байдлаар тэднийгээ зохицуулах вэ?
- С. Ажлаа зохицуулах чадварын тань талаар таны өмнөх дарга тань юу гэж хэлэх байсан бол?



**Хариулт**

- Сайн: С.** Энэ асуултын хариултын үнэн зөвийг шалгаж болох учир энэ тохиолдолд хамгийн хүчтэй асуулт. Ярилцагчийн сүүлчийн ажлыг газрын даргатай нь холбогдон энэ хүний талаар тодорхойлолт авч үнэн ярьсан эсэхийг нь шалгах боломжтой
- Дунд: В.** Энэ нь үйл явдал дээр тулгуурласан асуулт бөгөөд өмнө нь хийж үзээч үгүй зүйлээ ярилцагч нь уран яруугаар таныг итгэтэл ярьж чадах талтай.
- Муу: А.** Энэ бас л нэг хаалттай асуулт. Хэрэгцээтэй мэдээлэл энэ асуултаас олох нь боломжгүй боловч цаашлаад асуулт асууснаар /Яагаад өөрийгөө ингэж үнэлэв? Гэх мэт/ илүү боловсронгуй болгож болох юм.

**19. Асуудлыг шийдвэрлэх чадварыг тодорхойлохын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- А. Ямар нэг асуудалтай тулгарвал ямар тактикаар асуудалд ханддаг вэ?
- В. Өмнөх ажил дээрээ хир зэрэг асуудлыг шинжлэх үүргийг гүйцэтгэж байсан бэ?
- С. Өмнөх ажилдаа ажиллаж байхдаа тодорхой нэг асуудлыг олж илрүүлж байсан тохиолдол байсан уу?

**Хариулт**

- Сайн: С.** Энэ нь хамгийн хүчирхэг асуулт учир нь асуудлын мөн чанар болоод түүний болсон цаг хугацаатай нь мэдэх боломжтой. Хэрэв тийм эсвэл үгүй гэсэн хариултаар хариулбал ярилцагчаас ийм төрлийн асуудалтай тулгарвал ямар алхмаар шийдвэрлэх боломжтой вэ хэмээн үргэлжлүүлж болно
- Дунд: А.** Ок асуулт учир нь энэ үйл явдал дээр тулгуурласан асуулт
- Муу: В.** Энэ асуулт хэтэрхий өргөн хүрээг хамарсан учир таны энэ хүнийг ажилд авах шийдвэрт тань нөлөөлж чадахгүй.

**20. Бусадтайгаа хэрхэн хамтарч ажилладаг талаар мэдэхийн тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- А. Хамтран ажиллагсад чинь чамайг хир сайн багийн тоглогч гэж дүгнэдэг вэ?
- В. Өмнө нь ямар нэг байдлаар багийнхаа хэн нэгэн гишүүнтэй асуудал гаргаж байгаагүй биз дээ?
- С. Хамтран ажиллах хүмүүсийн ямар 3 чанар нь чамд хамгийн чухал вэ?

**Хариулт**

- Сайн: А.** Ярилцагч нь өөрийгөө гуравдагч биеийн төлөөллөөр ярьж байгаа учир энэ тохиолдолд хамгийн хүчирхэг асуулт. Энэ бол хариулахад амаргүй асуулт
- Дунд: С.** Энэ асуултаар ярилцагчийн хүмүүсийн ямар чанарт нь дуртайг мэдэх боломжтой. Мөн цаашлаад тодруулж асуух боломжтой



- Муу: В.** Иймэрхүү асуултанд хэн ч сөрөг хариулт өгөхгүй, аль аль талаараа үр дүнгүй асуулт

**21. Ярилцагчийн илүүд үздэг ажлын нөхцөл байдлыг мэдэхийн тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- A. Өөрийн ажиллахыг хүссэн орчноо дүрслээч?  
B. Ажиллах орчноос ямар 4 зүйл чамд хамгийн чухал вэ?  
C. Энэ ажлын зарыг уншаад хамгийн их чадвар боломжийг тань сорьсон ажил нь юу гэж бодсон?

**Хариулт**

- Сайн: С.** Энэ төрлийн мэдээлэлд хамгийн тохиромжтой асуулт. Энэ асуултаар ярилцагчийн ажлыг байрны болон танай байгууллагын талаар хир зэрэг судалгаа хийсэн гэдгийг мөн харж болно.  
 **Дунд: В.** Энэ нь муугүй асуулт, хариултыг сонсоод танай байгууллагад тохиромжтой үгүйг бодож үзэх хэрэгтэй  
 **Муу: А.** Энэ асуултыг асууснаар та ярилцагчийг таньд үлгэр ярьж өгөх боломжийг олгож байна.

**22. Ярилцагчийн зорилгыг олж мэдэхийн тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- A. 5 жилийн дараа өөрийгөө ямар байдалтай хаана харж байна?  
B. Богино хугацааны болон урт хугацааны зорилгоосоо хуваалцаач?  
C. Урт хугацааны чинь төлөвлөгөөтэй чинь энэ ажил хир зохицож байна?

**Хариулт**

- Сайн: В.** Ярилцагчийн зорилгыг цаг хугацааны хэм хэмжээнд хувааснаар энэ нь хамгийн хүчирхэг асуулт болж байна. Энд нэг чухал зүйл бол энэ хүний зорилго нь түүний орох гэж буй ажилтай ямар байдлаар холбогдож байна гэдгийг олж мэдэх  
 **Дунд: С.** Муугүй асуулт болов ч тийм үгүй гэсэн хариултаар хариулагдах боломжтой. Тиймээс үргэлжлүүлж асуулт асууж өргөжүүлж болно.  
 **Муу: А.** Хуучирсан асуулт. 5 жилийн дараахыг хэн ч урьдчилан хэлэх боломжгүй

**23. Танай байгууллагад хир удаан ажиллах хүн бэ гэдгийг олж тогтоохын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- A. Байгууллагын ирээдүйн талаар юу таны санааг зовинуулж байна?  
B. Энэ байгууллага болоод манай үйл ажиллагаагаа явуулж байгаа зах зээл ал зүг рүү явж байна гэж бодож байна?  
C. Энэ байгууллагад ажилласнаар юуг өөртөө олж авъя гэж бодож байна?

**Хариулт**

- Сайн: С.** “Чиний зорилго юу вэ ” гэсэн асуултын дараа явж болох сонгодог асуулт. Энэ асуултын хариултаас энэ хүн ерөнхийдөө танай байгууллагад хир удаан байх зураг нь тодорхой болно. Ж нь: би энэ хэлтсийнхээ захирал болох бодолтой нэсэн хүн хир удаан ажиллах бодолтой байга нь ойлгомжтой биз ээ.
- Дунд: А.** Энэ асуулт нь ярилцагчийн энэ байгууллагад хир удаан байхыг нь хэлж өгөхгүй боловч энэ хүний танай байгууллагын талаар ямар нэг судалгаа хийсэн үгүйг мэдэх боломжтой
- Муу: В.** Энэ асуулт нь “чи ямар судалгаа хийсэн бэ” гэж асуухын оронд “чи юу гэж бодож байна ” гэдэг дээр анхаарсан. Авахыг хүссэн мэдээлэлд тань тэр хүний юу гэж бодож байгаа нь одоо таньд тийм ч чухал биш харин тэр хүн ямар чадвартай вэ гэдэг нь чухал

**24. Ярилцагчийн яагаад танай байгууллагад ажиллахыг хүссэнийг нь олж мэдэхийн тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- А. Юу таны сонирхлыг төрүүлж энэ байгууллагад, энэ албан тушаалд орохоор шийдсэн бэ?
- В. Энэ ажлын юунд нь та татагдсан юм бэ?
- С. Энэ ажлын байр албан тушаалыг өөрийн сүүлчийн ажлын байртайгаа хэрхэн харьцуулах вэ?

#### **Хариулт**

- Сайн: С.** Хүчирхэг үндсэн асуулт. Сүүлчийн ажлынхаа юунд нь дуртай байсан энэ нь таны санал болгож байгаа ажлын байртай хир нийцэж байна гэдгийг шинжлэх боломжтой. Дахин асуулт асуух замаар улам тодруулан бататгаж болдог.
- Дунд: А.** Энэ асуултын хариу нь ухаж асуухаас нааш ямар нэг тодорхой мэдээлэл өгч чадахгүй байх талтай. Өгч байгаа хариултаудаас нь шалтгаалаад ажил дээрх ямар хариуцлагууд нь таньд сонирхолтой байдаг гэх мэт асуултыг асууж болно.
- Муу: В.** Энэ асуулт нь ярилцагчийн талаар хангалттай мэдээллийг өгөх боломжгүй. Энэ ажлын байранд шаардлагатай ур чадвар болон чиний өөрийн чинь ур чадвар 2 хир зэрэг зохицож байна гэх зэрэг нэмэлт асуултыг асууж болно.

**25. Яагаад өмнөх ажлаа орхих болсон шатгааныг нь тогтоохын тулд та аль асуултыг асуувал илүү тохиромжтой гэж бодож байна вэ?**

- А. Өмнөх ажлаа 1-10 онооны хооронд үнэл гэвэл яаж үнэлэх вэ?
- В. Энэ цаг хугацаанд өмнөх ажлаа орхих болсон ямар нэг тодорхой шалтгаан байна уу?
- С. Хэзээнээс эхлээд өмнөх ажлаа солихоор шийдсэн бэ?

#### **Хариулт**

- Сайн: В.** “Энэ цаг хугацаанд” гэдгийг оруулж өгснөөрөө энэ асуулт хүчирхэг болж чадаж байна. Ерөнхийдөө “чи яагаад өмнө нь биш яг одоо ажлаа орхиж байгаа” гэдгийг асууж байгаа юм
- Дунд: С.** Энэ асуулт нь ярилцагч өмнөх ажилдаа сэтгэл хангалуун байсан эсэхийг тогтооно.
- Муу: А.** Нарийвчлан асуухаас нааш хэрэгцээтэй мэдээлэл өгөх боломжгүй асуулт

Дээрх асуултууд таны ажил горилогчид тавьдаг асуултуудтай харьцуулахад ямар байв даа? Та асуултаа зөв асуух нь ажил горилогчийг таньж мэдэхэд ихээхэн ач холбогдолтойг та ойлгосон байх гэдэгт итгэлтэй байна.

Ажил горилогчийг таньж мэдэх, зөв хүнээ ярилцлагын болон эссэ бичүүлэх аргаар таньж мэдэхтэй холбоотой сургалт, зөвлөгөө хэрэгтэй бол Голомт банкны Бизнес хөгжлийн газарт хандана уу.

Анхаарал тавьсан танд баярлалаа.